



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/94/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: Утас: 70523020 Аудитор:	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.Хараат бус аудиторын дүгнэлт



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.23 № 1-6/72
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЧУЛУУНТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Завсрын аудитаар тус байгууллагын үндсэн хөрөнгөд түүвэрчилсэн хяналтын тооллого явуулахад тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 2022 онд бүртгэлд тусгасан 2,522,500 төгрөгийн үнэ бүхий 00437 бүртгэлийн кодтой HP laptop 17 маркийн зөөврийн компьютер дутаасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө, эд хөрөнгө дутагдсан үед заавал хийнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ", 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Сангийн Сайдын 2000 оны 69 дүгээр тогтоолоор баталсан Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 6 дугаар зүйлд "Эд хариуцагч энэ дүрмийн шаардлагыг зөрчих, хариуцсан өмч хөрөнгийг гэмтээж чанар алдагдуулах, тооцоог будлиантуулах, идэж ашиглах үрэгдүүлсэн явдал илэрвэл хууль зүйн дагуу зохих хариуцлагыг хүлээж, гарсан хохирлыг учирсан хохирлоор шууд тооцож, тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцон, нөхөн төлж барагдуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

442505043

Албан томилолтоор ажилласан 11 албан хаагчид хоол, унааны хөнгөлөлт 560,000 (таван зуун жаран мянган) төгрөгийг давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.3-д "хоолны зардал" гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 3 дугаар улирлын санхүүгийн тайланд тусгасан бараа үйлчилгээний зардлын 3,468,840 төгрөг, байгууллага болон хувь хүмүүст төлөх 8,104,480 төгрөг нийт 11,573,320 төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Тус байгууллага нь тайлант оны эцэст 172,290 төгрөгийн авлага, 7,828,795.5 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн баталгаажуулаагүй байна.

Байгууллагын бараа материалын дансанд нийт 196,946.3 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгаа ба зарцуулсан бараа материалын зарлагыг тухай бүр хийгээгүй улмаас үлдэгдлээр тайлагнасан байна.

Байгууллагын эд хөрөнгөд хяналтын тооллого явуулахад эд хөрөнгийг НББ-д тусгагдсан кодоор эзэмшигч бүрээр картжуулж хэвшээгүй, тооллогын явцад тухайн хөрөнгийг мөн эсэхийг батлах боломжгүй байсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д заасан шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр нөөцлөхийг хориглоно гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад асуудлын хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

4417144353
ЕЮА0056 9025707

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	218,316,382.53	259,524,388.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,422,555.00	2,222,555.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,422,555.00	2,222,555.00
3121	Төгрөг	6,422,555.00	2,222,555.00
31211	Төрийн сангийн харилцах	6,422,555.00	2,222,555.00
33	АВЛАГА	27,763,367.32	59,635,450.82
335	Бусад авлага	27,763,367.32	59,635,450.82
3351	Байгууллагаас авах авлага	27,763,367.32	59,635,450.82
35	БАРАА МАТЕРИАЛ	184,130,460.21	197,666,382.41
354	Хангамжийн материал	176,002,540.21	193,842,422.41
35410	Бичиг хэргийн материал	3,299,800.00	5,836,900.00
35420	Аж ахуйн материал	55,809,377.71	64,078,889.91
35430	Сэлбэг хэрэгсэл	19,086,150.00	26,840,670.00
35440	Түлш, шатах тослох материал	-	831,000.00
35450	Барилгын засварын материал	1,500,000.00	1,500,000.00
35470	Бусад хангамжийн материал	96,307,212.50	94,754,962.50
35600	Мал амьтад	8,127,920.00	3,823,960.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,831,880,763.38	2,838,423,461.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,831,880,763.38	2,838,423,461.97
392	Биет хөрөнгө	2,742,482,763.38	2,748,928,239.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,478,229,138.96	1,475,781,328.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(115,803,821.34)	(150,032,459.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	458,637,850.00	611,615,350.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(154,985,484.97)	(158,030,647.34)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,741,366.00	88,370,877.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,050,073.69)	(32,775,047.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,806,982.60	61,627,432.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,580,444.49)	(27,016,105.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,714,221,427.60	1,431,982,731.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(727,734,177.29)	(552,595,221.67)
393	Биет бус хөрөнгө	89,398,000.00	89,495,222.20
39301	Програм хангамж	3,586,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,586,000.00)	(2,777.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	89,398,000.00	89,398,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,050,197,145.91	3,097,947,850.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,463,088.33	37,605,406.57
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,463,088.33	37,605,406.57
413	Өглөг	5,463,088.33	37,605,406.57
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	106,522.33	11,648,416.57
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	13,560,220.00
4136	Бусад өглөг	5,356,566.00	12,396,770.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,197,066.00	6,498,650.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	159,500.00	5,898,120.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,044,734,057.58	3,060,342,443.63
51	Засгийн газрын хувь оролцоо	3,044,734,057.58	3,060,342,443.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,405,764,735.81	1,405,764,735.81
512	Хуримтлагдсан үр дүн	1,478,532,890.92	1,494,141,276.97
51210	Өмнөх үеийн үр дүн	1,478,532,890.92	1,478,532,890.92
51220	Тайлант үеийн үр дүн	-	15,608,386.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,436,430.85	160,436,430.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,050,197,145.91	3,097,947,850.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,946,114,960.84	1,358,260,050.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	545,177,552.00	305,995,701.93
120	Нийтлэг татварын бус орлого	545,177,552.00	305,995,701.93

Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	545,177,552.00	305,995,701.93
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,276,000.00	3,802,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	541,901,552.00	302,193,701.93
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө-Үндсэн хөрөнгө	500,866,082.00	279,402,261.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө-Бараа материал	41,035,470.00	22,791,440.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,400,937,408.84	1,052,264,349.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	427,554,457.00	50,136,849.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	362,568,623.00	23,062,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	64,985,834.00	27,074,449.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	973,382,951.84	1,002,127,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	973,382,951.84	1,002,127,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,661,134,358.71	1,262,189,441.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,661,134,358.71	1,262,189,441.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,650,634,358.71	1,248,908,154.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,450,223.75	781,241,543.34
210101	Үндсэн цалин	345,174,350.00	422,041,885.29
210102	Нэмэгдэл	268,633,073.75	315,094,623.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,800,600.00	17,520,955.00
210104	Урамшуулал	24,842,200.00	26,584,079.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,560,641.78	99,816,703.21
210201	Тэтгэврийн даатгал	60,696,673.28	68,967,450.42
210202	Тэтгэмжийн даатгал	5,891,880.00	7,747,553.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,006,547.50	3,873,776.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,463,700.00	3,840,136.80
210205	Эрүүл мэндийн даатгал	13,501,841.00	15,387,785.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,315,566.39	44,389,767.53
210301	Гэрэл, цахилгаан	6,464,861.39	7,921,962.53
210302	Түлш, халаалт	35,550,625.00	36,201,935.00
210303	Цэвэр, бохир ус	300,080.00	265,870.00
2104	Хангамж, бараа материалын зардал	80,841,884.81	50,886,100.81
210401	Бичиг хэрэг	5,251,938.89	4,495,750.01
210402	Тээвэр, шатахуун	34,740,407.00	29,668,270.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,834,137.00	4,571,753.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,449,000.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	35,566,401.92	12,150,327.80
2105	Нормативт зардал	12,349,244.00	15,152,940.00
210502	Хоол, хүнс	12,349,244.00	15,152,940.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,161,058.33	3,035,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	53,608.33	-
210604	Урсгал засвар	21,107,450.00	3,035,000.00
2107	Томилолт, зочны зардал	14,494,500.00	23,695,000.00
210702	Дотоод албан томилолт	14,494,500.00	23,695,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,338,654.00	23,044,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,067,500.00	22,344,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	700,000.00	700,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285,314.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	-
210807	Газрын төлбөр	197,840.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	668,122,585.65	207,646,299.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	437,572,682.00	10,393,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	955,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	230,549,903.65	196,297,549.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,500,000.00	13,281,286.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,500,000.00	4,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,500,000.00	4,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,131,286.66
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,131,286.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	284,980,602.13	96,070,609.68
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,060,074.06	80,462,223.63
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,356,924.06	-

Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	7,920,700.00	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	75,998,263.63
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	1,782,450.00	4,463,960.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,060,074.06)	(80,462,223.63)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	273,920,528.07	15,608,386.05

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,433,805,222.16	1,082,755,016.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,276,000.00	3,802,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,276,000.00	3,802,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,276,000.00	3,802,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,276,000.00	3,802,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,430,529,222.16	1,078,953,016.32
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	457,146,270.32	76,825,516.32
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	362,568,623.00	23,062,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	94,577,647.32	53,763,116.32
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	973,382,951.84	1,002,127,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	973,382,951.84	1,002,127,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,397,766,754.84	1,086,955,016.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,397,766,754.84	1,086,955,016.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,386,668,754.84	1,012,325,678.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,509,139.75	769,668,368.05
210101	Үндсэн цалин	345,233,266.00	410,468,710.00
210102	Нэмэгдэл	268,633,073.75	315,094,623.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,800,600.00	17,520,955.00
210104	Урамшуулал	24,842,200.00	26,584,079.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,317,539.70	99,847,984.26
210201	Тэтгэврийн даатгал	60,453,571.20	68,998,731.47
210202	Тэтгэмжийн даатгал	5,891,880.00	7,747,553.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,006,547.50	3,873,776.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,463,700.00	3,840,136.80
210205	Эрүүл мэндийн даатгал	13,501,841.00	15,387,785.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,315,566.39	44,389,767.53
210301	Гэрэл, цахилгаан	6,464,861.39	7,921,962.53
210302	Түлш, халаалт	35,550,625.00	36,201,935.00
210303	Цэвэр, бохир ус	300,080.00	265,870.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,503,467.00	29,962,673.00
210401	Бичиг хэрэг	3,720,300.00	2,384,100.00
210402	Тээвэр, шатахуун	24,150,530.00	22,048,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,834,137.00	4,571,753.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,798,500.00	958,200.00
2105	Нормативт зардал	-	440,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,609,000.00	4,606,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	79,800.00	-
210602	Тавилга	675,000.00	-
210604	Урсгал засвар	27,854,200.00	4,606,940.00
2107	Томилолт, зочны зардал	14,547,500.00	15,365,000.00
210702	Дотоод албан томилолт	14,547,500.00	15,365,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,193,432.00	27,154,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,922,278.00	26,454,980.00
210803	Даатгалын үйлчилгээ	700,000.00	700,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285,314.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	-
210807	Газрын төлбөр	197,840.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	427,673,110.00	20,889,966.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	427,673,110.00	19,934,966.00

Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	955,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,098,000.00	74,629,337.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,098,000.00	5,909,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,098,000.00	5,909,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,131,286.66
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,131,286.66
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	59,588,750.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		59,588,750.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	36,038,467.32	(4,200,000.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,349,800.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,349,800.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	9,349,800.00	-
222001	Тоног төхөөрөмж	8,349,800.00	-
223001	Бусад хөрөнгө	1,000,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,349,800.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	26,688,667.32	(4,200,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,422,555.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,422,555.00	2,222,555.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгсгөлөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,764,735.81	160,436,430.85	1,204,612,362.85	2,770,813,529.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,405,764,735.81	160,436,430.85	1,204,612,362.85	2,770,813,529.51
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	273,920,528.07	273,920,528.07
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,764,735.81	160,436,430.85	1,478,532,890.92	3,044,734,057.58
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,405,764,735.81	160,436,430.85	1,478,532,890.92	3,044,734,057.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,405,764,735.81	160,436,430.85	1,478,532,890.92	3,044,734,057.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	15,608,386.05	15,608,386.05
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,764,735.81	160,436,430.85	1,494,141,276.97	3,060,342,443.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,045,966,000.00	1,000,998,213.34	44,967,786.66	95.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,045,966,000.00	1,000,998,213.34	44,967,786.66	95.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,043,166,000.00	995,088,913.34	48,077,086.66	95.4

Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	773,652,900.00	769,395,168.55	4,257,731.45	99.4
210101	Үндсэн цалин	407,986,800.00	410,468,710.00	(2,481,910.00)	100.6
210102	Нэмэгдэл	330,602,700.00	315,094,623.09	15,508,076.91	95.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,620,000.00	17,520,955.00	(1,900,955.00)	112.2
210104	Урамшуулал	19,443,400.00	26,310,880.46	(6,867,480.46)	135.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,229,100.00	99,847,984.26	381,115.74	99.6
210201	Тэтгэврийн даатгал	69,083,100.00	68,998,731.47	84,368.53	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	7,786,500.00	7,747,553.26	38,946.74	99.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,893,200.00	3,873,776.74	19,423.26	99.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,893,200.00	3,840,136.80	53,063.20	98.6
210205	Эрүүл мэндийн даатгал	15,573,100.00	15,387,785.99	185,314.01	98.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,433,600.00	44,389,767.53	2,043,832.47	95.6
210301	Гэрэл, цахилгаан	10,986,300.00	7,921,962.53	3,064,337.47	72.1
210302	Түлш, халаалт	35,056,500.00	36,201,935.00	(1,145,435.00)	103.3
210303	Цэвэр, бохир ус	390,800.00	265,870.00	124,930.00	68.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,849,800.00	29,207,673.00	11,642,127.00	71.5
210401	Бичиг хэрэг	4,819,000.00	1,629,100.00	3,189,900.00	33.8
210402	Тээвэр, шатахуун	29,402,800.00	22,048,620.00	7,354,180.00	75.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,684,000.00	4,571,753.00	112,247.00	97.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	-	144,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	958,200.00	841,800.00	53.2
2105	Нормативт зардал	440,000.00	440,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	440,000.00	440,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,305,000.00	4,606,940.00	8,698,060.00	34.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	-	0.00	-
210604	Урсгал засвар	13,305,000.00	4,606,940.00	8,698,060.00	34.6
2107	Томилолт, зочны зардал	22,091,500.00	13,865,000.00	8,226,500.00	62.8
210702	Дотоод албан томилолт	22,091,500.00	13,865,000.00	8,226,500.00	62.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,964,100.00	27,154,980.00	10,809,120.00	71.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,271,100.00	26,454,980.00	9,816,120.00	72.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	700,000.00	700,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	513,000.00	-	513,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	-	180,000.00	-
210807	Газрын төлбөр	300,000.00	-	300,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,200,000.00	6,181,400.00	2,018,600.00	75.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500,000.00	5,226,400.00	273,600.00	95.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,700,000.00	955,000.00	1,745,000.00	35.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,800,000.00	5,909,300.00	(3,109,300.00)	211.0

Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,800,000.00	5,909,300.00	(3,109,300.00)	211.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	5,909,300.00	(3,109,300.00)	211.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,045,966,000.00	996,798,213.34	49,167,786.66	95.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,045,466,000.00	992,996,213.34	52,469,786.66	95.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,045,466,000.00	992,996,213.34	52,469,786.66	95.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	3,802,000.00	(3,302,000.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	3,802,000.00	(3,302,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,422,555.00	(6,422,555.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,222,555.00	(2,222,555.00)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	21.00	4.00	84.0
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	5.00	5.00	50.0
620003	Үйлчлэх ажилтан	8.00	9.00	(1.00)	112.5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	21.00	4.00	84.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	6.00	3.00	66.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	10.00	9.00	1.00	90.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	76,825,516.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	76,825,516.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	17,236,765.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	273,199.50
210104	Урамшуулал	-	273,199.50
2104	Хангамж, бараа материалын зардал	-	755,000.00
210401	Бичиг хэрэг	-	755,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,708,566.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,708,566.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	59,588,750.82
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	59,588,750.82
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		59,588,750.82
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	76,825,516.32
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	76,825,516.32
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	23,062,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	53,763,116.32

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 83,515.6 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 68,028.8 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад бүрэн залруулж, залруулагдаагүй 7 зөрчилд 3,082.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 12,404.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 15,251.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 235.8 мянган төгрөгөөр их байх тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1. Залруулсан алдаа

1. Нэмэлт санхүүжилтийн харилцах дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 59,588.8 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүйг залруулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.4-т “аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” гэж заасныг зөрчсөн, Хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдээдлийг хангаагүй байна.
2. Тайлант хугацаанд худалдан авсан 104.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаар бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.4-т “аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” гэж заасныг зөрчсөн, Хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдээдлийг хангаагүй байна.
3. Нэмэлт санхүүжилтийн данснаас хийгдсэн 8,062.1 мянган төгрөгийн орлого, 273.1 мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээг НББ-д бүртгэлд тусгаагүйг залруулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.4-т “аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” гэж заасныг зөрчсөн, Хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдээдлийг хангаагүй байна.

5.2. Төлбөрийн акт

1. Завсрын аудитаар албан томилолтоор ажилласан 11 албан хаагчид 560,000 төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.3-д “хоолны зардал” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Завсрын аудитаар тус байгууллагын үндсэн хөрөнгөд түүвэрчилсэн хяналтын тооллого явуулахад тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 2022 онд бүртгэлд тусгасан 2,522,500 төгрөгийн үнэ бүхий 00437 бүртгэлийн кодтой HP laptop 17 маркийн зөөврийн компьютер дутаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө, эд хөрөнгө дутагдсан үед заавал хийнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ”, 12.4-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний

өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 “*Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна*”, Сангийн Сайдын 2000 оны 69 дүгээр тогтоолоор баталсан Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 6 дугаар зүйлд “*Эд хариуцагч энэ дүрмийн шаардлагыг зөрчих, хариуцсан өмч хөрөнгийг гэмтээж чанар алдагдуулах, тооцоог будлиантуулах, идэж ашиглах үрэгдүүлсэн явдал илэрвэл хууль зүйн дагуу зохих хариуцлагыг хүлээж, гарсан хохирлыг учирсан хохирлоор шууд тооцож, тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцон, нөхөн төлж барагдуулна*” гэж заасантай нийцэхгүй байна.

5.2. Албан шаардлага

1. Завсрын аудитаар СТ-1-т тусгагдсан нийт 16,648.1 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлээс 3,468.8 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өглөг, 8,104.5 мянган төгрөгийн байгууллага болон хувь хүмүүст төлөх өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*Ерөнхий нягтлан бодогч нь ... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах*”, 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Эд хариуцагч бараа материалын тайланг холбогдох хууль болон төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, аргачлалд заасны дагуу анхан шатны баримтыг үндэслэхгүй бэлтгэсэн, нягтлан бодогч хуульд заасан эрх, үүргийн хүрээнд хяналт хэрэгжүүлэхгүй санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “*Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*”, 13.5-д “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно*”, Сангийн Сайдын 2000 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 16-д “*Мөнгөн хөрөнгө, бараа материалын үнэт зүйлийг хүлээн авах, тавьж олгох, борлуулах ажлыг дагалдах баримт, хуваарь, лимит зэргийг харгалзан өөрийн биеэр заавал шалган тоолж гүйцэтгэх ба орлого, зарлагын баримт, анхан шатны бүртгэлийн заавар, баримт бичилтийн дүрмийн шаардлагын дагуу цаг тухайд нь цэвэр нямбай, засваргүйгээр үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна*”, Сангийн Сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн ААНБ-д нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 3.6-д шаардах хуудас: “*Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ*”, 3.9-д “*Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна*” гэж заасантай нийцэхгүй байна.

3. Тус байгууллага тайлан хугацааны эцэст 300 литр 831,000 төгрөгийн шатахуун нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “*нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно*” гэж заасантай нийцэхгүй байна.

5.3. Зөвлөмж

1. Бараа материалын тайлантай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Байгууллагын бараа материалын дансанд нийт 196,946.3 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгаа ба зарцуулсан бараа материалын зарлагыг тухай бүр хийгээгүй улмаас үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө заавал хийнэ”, 14.4.6-д “нягтлан бодох бүртгэлд бүх зардлыг заавал бүртгэнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Сангийн Сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн ААНБ-д нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 3.3-т зарлагын баримт, 3.6-д шаардах хуудас: “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ”, 3.9-д “Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна” гэж заасантай нийцээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалыг зарцуулалт хийсэн дариуд нягтлан бодох бүртгэлийн хөтөлж, жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай зохион байгуулж хэвших, зарцуулсан бараа материалыг данс бүртгэлээс анхан шатны баримтад үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх;

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Байгууллагын эд хөрөнгөд хяналтын тооллого явуулахад эд хөрөнгийг НББ-д тусгагдсан кодоор эзэмшигч бүрээр картжуулж хэвшээгүй, тооллогын явцад тухайн хөрөнгийг мөн эсэхийг батлах боломжгүй байсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 онд 15 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.2.2-т “Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна

2.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлд хариуцлагатай албан хаагчдыг томилж, эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулах, эд хөрөнгийг эзэмшигч бүрээр картжуулж, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг албан хаагч бүртэй байгуулж, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтад хяналт тавьж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагыг санхүүгийн тайланд тусгаагүй	1	8,335.2	1	8,335.2			1	8,335.2		
Худалдан авсан БМ-ыг үнэ төлбөргүй хүлээн авсанаар бүртгэсэн	1	104.8			1	104.8	1	104.8		
Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлсэн үлдэгдлийг бүртгэл тайланд тусгаагүй	1	59,588.8	1	59,588.8			1	59,588.8		
Дүн	3	68,028.8	2	67,924.0	1	104.8	3	68,028.8		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Томилолтоор ажилласан албан хаагчид хоолны мөнгө давхардуулан олгосон	1	560.0	1	560.0				
Хяналтын тооллогоор хөрөнгө дутсан	1	2,522.5	1	2,522.5				
Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгуулаагүй	1	11,573.3			1	11,573.3		
Холбогдох анхан шатны баримтыг үндэслэхгүй эд хариуцагчийн тайланг бэлтгэсэн, нягтлан бодогч хуульд заасан эрх үүргийн хүрээнд хяналт хэрэгжүүлэхгүй санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан	1	-			1	-		
Хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй	1	-					1	-
Зарцуулсан бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан	1	-					1	-
Дүн	6	14,655.8	2	3,082.5	2	11,573.3	2	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй.	1	831.0			1	831.0		
Дүн	1	831.0			1	831.0		
Нийт дүн	7	15,486.8	2	3,082.5	3	12,404.3	2	-